



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 09/40

Мандалговь

“Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж /Дундговь Эрдэнэдалай, Сайхан-Овоо сум/”  
нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний  
хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Засаг даргын Тамгын газрын автомашин, тоног төхөөрөмж /Дундговь Эрдэнэдалай, Сайхан-Овоо сум/” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Одончимэг (Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Ц.Эрдэнээ (Иргэний төлөөлөл)

Б.Батхүү (Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

О.Сэргэлэн (Дундговь –Ус Орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын ХАА хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Одончимэг)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  
Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482069160